



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

2023

ХУРЛЫН МАТЕРИАЛ





БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

2023

ХУРЛЫН МАТЕРИАЛ



“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

“Богд банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 23/22 тоот тогтоолын гуравдугаар хавсралт

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 23/22 тоот тогтоол;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
4. Компанийн 2022 оны санхүү болон үйл ажиллагааны тайлан;
5. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
6. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлын “Ногдол ашиг хуваарилах тухай” 23/09 тоот тогтоол;
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийн төсөл;
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд;
11. ТУЗ-гишүүнд нэр дэвшигчийн товч танилцуулга;
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд ХЭ-ээс санал өгөх саналын хуудас.

Компанийн тухай хуулийн 65.6-д заасан заалттай холбогдуулан хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулах зорилгоор дараах зүйлсийг компанийн вэб хуудас болох <https://www.bogdbank.com/> хаягт байршуулсан тул та бүхнийг эдгээр материалтай танилцахыг хүсэж байна. Үүнд:

1. Компанийн 2022 оны жилийн санхүүгийн тайлан;
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
3. Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан;
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний танилцуулга;
5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв;
7. Компанийн дүрэм;

Дээр дурдсан баримт бичиг нь 2023 оны 03 сарын 22-ны өдрийн дотор бэлэн болсон байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2023.03.13

№ 23/22

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.15, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Богд Банк” ХК-ийн Дүрэм холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 13-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Богд Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал/ гэх/-ыг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 11:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшн-ыг ашиглан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Ээлжит хурал зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 03 сарын 14-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай..
3. Ээлжит хурал хуралдуулах тухай зар мэдээг компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёр сониноор дамжуулан 2023 оны 03 сарын 16, 2023 оны 03 сарын 31-ны өдөр тус тус мэдээлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 сарын 03-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - I. “Богд банк” ХК-ийн 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - II. Ногдол ашиг хэрхэн хуваарилах гэж байгаа талаар товч танилцуулга;
 - III. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах;
 - IV. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, шинээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох тухай;
6. Ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигч нарт хүргэх хурлын материалыг 2023 оны 03 сарын 22-ны өдөрт багтаан бэлтгэж үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлж хувьцаа эзэмшигчдээс хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломж бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
Үүнд:
Комиссын дарга:
Б.Онон /“Би Ди Сэк ҮЦК”ХК-ийн менежер/
Гишүүд: Т.Уянга
8. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:
С.Оргодол /Богд банк ХК-ийн Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч/
Гишүүд:
Б.Сэргэлэн /Захиргаа, хүний нөөцийн газрын захирал/
Т.Уянга /Хуульч/
Р.Нямцэрэн /ТУЗ-н нарийн бичгийн дарга/
Д.Төрмандах /Богд банк ХК-ийн Ерөнхий аудитор/
9. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг нэгдүгээр, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг”-ийг хоёрдугаар, хэлэлцэх асуудалтай холбогдож “Хувьцаа эзэмшигчид танилцуулах баримт бичгийн жагсаалт”-ыг гуравдугаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдээс санал авах, “Санал авах хуудас”-ыг дөрөвдүгээр, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох санал авах хуудсыг тавдугаар, ХЭ-ийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг саналын хуудасны хавсралтаар тус тус баталсугай.
10. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж “БиДиСек” ҮЦК ХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, төв байр хаягаар дамжуулан авах ба энэхүү саналын хуудсыг авах сүүлийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 15:00 цаг байхаар тогтоосугай.
11. Хурлын даргаар “Богд Банк” ХК-ийн ТУЗ-ийн дарга /Л. Болдхуяг/-ыг томилсугай.
12. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга /С.Оргодол/-д даалгасугай.
13. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Р.Нямцэрэн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

БОГД БАНК ХК

“Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн
23/03 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ЗАР



Компанийн нэр: “Богд Банк” ХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бодь цамхаг

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11:00 цагт болно

Хурал зохион байгуулах хэлбэр: “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшн-ыг ашиглан цахим хуудсаар хуралдана

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 04 сарын 03-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Богд банк” ХК-ийн 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Ногдол ашиг хэрхэн хуваарилах гэж байгаа талаар товч танилцуулга;
3. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах;
4. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, шинээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох тухай;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

- Хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг түүний танилцуулга, түүний талаар таны санал өгөх саналын хуудасны хамт таны харьцдаг Үнэт цаасны компанид хүргүүлсэн байгаа
- Та тус Үнэт цаасны компанитай холбогдон хурлын материалаа авахыг хүсье.

Хувьцаа эзэмшигч та 2023 оны 04 сарын 21-ний өдрийн 15:00 цагаас өмнө ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл <https://www.bogdbank.com/> цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр, Хаяг: Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
- “Богд Банк” ХК-ийн байранд ирж хурал зохион байгуулах комиссын гишүүн Т.Уянгад /утас: 99051320/ мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилан өгөх боломжоор хангаж “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр, Хаяг: Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот /Б.Онон утас 99043165/ хаягаар дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2023 оны 4 сарын 21-ний өдрийн 15:00 цаг байна.

Холбоо барих: 75771199,7555-1919,

И-мэйл хаяг: info@bogdbank.com, broker@bdsec.mn

Хурал зохион байгуулах комисс-той доорх хаягаар холбоо барина уу:

Гишүүн: Т.Уянга

Email: uyanga.t@bogdbank.com

Утас: 99051320

“Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн
Эхлээд тогтоолын хоёрдугаар дугаар хавсралт

**“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДЭГ**

Хурал 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 11:00 цагт эхэлнэ.



1	Хурал болох өдрөөс өмнө саналаа ирүүлсэн Хувьцаа эзэмшигчид болон цахимаар хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж хурлын ирцийн талаар тооллогын комиссын шийдвэр гаргаж хурлын дарга болон хуралд цахимаар оролцож буй Хувьцаа эзэмшигч нарт танилцуулах	11:00-11:10	Тооллогын комисс
2	Хурлын дарга хурлыг нээж хурлын дэгийг танилцуулах	11:10-11:15	Хурлын дарга
3	Хэлэлцэх асуудлын дагуу дараах асуудлуудыг хэлэлцүүлнэ. Үүнд:	11:15-12:20	Хурлын дарга
	1. “Богд Банк” ХК-ийн 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах	11:15-11:30	Гүйцэтгэх захирал
	2. Ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга;		
	3. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах;	11:30-11:35	ТУЗ-ийн дарга
	4. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, шинээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох тухай;	11:35-12:20	Гүйцэтгэх захирал
4	Хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	12:20-12:30	Хуралд оролцогчид
5	Хурлаас гарах шийдвэрийн төсөл бүрийг танилцуулах	12:30-12:35	Хурлын дарга
6	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт	12:35-12:40	Хуралд оролцогчид
7	Хуралд цахимаар оролцож буй Хувьцаа эзэмшигчид болон Хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн оролцогчдоос хурлаас гарах шийдвэрт өгөх саналаа тусгасан саналын хуудсыг хүлээн авах	12:40-13:00	Тооллогын комисс
8	Завсарлага	13:00-13:10	Хурал зохион байгуулах комисс
9	Хуралд цахимаар оролцож буй Хувьцаа эзэмшигчид болон Хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн оролцогчдоос хурлаас гарах шийдвэрт өгөх саналыг хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэх	13:10-13:30	Тооллогын комисс

10	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар саналаа ирүүлсэн Хувьцаа эзэмшигчдийн саналыг тоолж хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэх	13:30-14:00	Тооллогын комисс
11	Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн Хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг тооллогын комиссын тогтоол болгон гаргах.	14:00-14:10	Тооллогын комисс
12	Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хурлаас гарах тогтоолыг боловруулах	14:10-14:20	Тооллогын комисс
13	Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн Хувьцаа эзэмшигчдийн саналын дүнгээр гарсан тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	14:20-14:25	Тооллогын комисс
14	Хурлаас гарах шийдвэрийг танилцуулах	14:25-14:30	Хурлын дарга
15	Хурлыг хаах	14:30	Хурлын дарга

—-000—-

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ нь банкны үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлагын банкны үйл ажиллагаанд мөрдүүлэх, зохион байгуулах ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг. Мөн түүнчлэн, банкны удирдлага, зохион байгуулалтын ерөнхий бүтэц захиргааны зардлын хэмжээг тогтоох, гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилох, түүнийг ажлаас түдгэлзүүлэх, чөлөөлөх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, олгох цалин шагнал урамшуулал, үүрэг хариуцлагын хэмжээг тогтоох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ХЭХ-аар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох, банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулах зэрэг эрхтэй.

Богд Банкны ТУЗ нь 6 ердийн болон 3 хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүнтэй. ТУЗ-ийн гишүүд нь Монголбанкнаас тавигдсан шалгуурыг хангасан, банк, санхүүгийн салбарт хамгийн багадаа 15 жил ажилласан туршлагатай байна. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүнээр ажилладаг. ТУЗ-ийн гишүүд бүрийн бүрэн эрхийн хугацаа дараагийн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд гишүүдийг улируулан сонгож болохоор зохицуулсан байна.

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр	Эрхэлж байгаа ажил	Томилогдсон	Төлөв
1	Л.Болдхуяг	Богд банкны ТУЗ-ийн дарга	2014.10.31	Ердийн
2	Г.Саруул	ТУЗ гишүүн, Гүйцэтгэх захирал	2014.10.31	Ердийн
3	Ж.Нарантуяа	ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зөвлөх	2014.10.31	Хараат бус
4	Э.Бямбажав	"Их тусч" ХХК-ийн захирал	2022.07.06	Хараат бус
5	Рожер Томас Моеэс	FSIP төслийн Финтекийн ахлах зөвлөх	2022.09.14	Хараат бус
6	Д.Моломжамц	ОУ-ын Хөрөнгө Оруулалтын банкны зөвлөх	2018.05.09	Ердийн
7	ЖАН ТОРСТЭН	ТУЗ гишүүн	2018.12.31	Ердийн
8	ЭЛЛИОТ РОВАН Аукланд	ОУ-ын Хөрөнгө Оруулалтын Банкны Бизнес төлөвлөлт, санхүүгийн загварчлалын албаны дарга	2021.02.15	Ердийн
9	Б.Ойгонжаргал	Жем Интернэшнл ХХК, Ерөнхийлөгч	2022.07.06	Ердийн
10	Р.Нямцэрэн	Богд банкны ахлах хуульч, ТУЗ-н нарийн бичгийн дарга	2020.03.02	Нарийн бичгийн дарга

Банкны ТУЗ нь Эрсдэлийн Удирдлага, Аудит, Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын гэх гурван хорооны үйл ажиллагааг хариуцан удирддаг.

- Эрсдэлийн удирдлагын хороо
- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хороо

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлангийн үйл явц, дотоод хяналтын систем болон санхүүгийн эрсдэлийн менежмент, аудитын үйл явц, комплайнс буюу хуулийн нийцлийн асуудал болон холбогдох хууль тогтоомж, Банкны дотоод дүрэм, журмын дагуу хянахад ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Бямбажав, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Д.Моломжамц, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, ТУЗ-ийн хараат бус гишүүн Рожер Томас Моеэс нар ажиллаж байна.

НЭР ДЭВШҮҮЛЭХ, ҮНЭЛГЭЭ УРАМШУУЛЛЫН ХОРОО

Банкинд мөрдөгдөж буй цалин урамшууллын бодлогын хэрэгжилт, гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон банкны урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсан эсэхэд хяналт тавих, ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын хэмжээг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушуултны үйл ажиллагааг идэвхжүүлэх үүрэгтэй. Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Торстен Дазер, ТУЗ-ийн гишүүн Эллиотт Аукланд, нар байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, хянах замаар Банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах, эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгон хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Бямбажав, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Д.Моломжамц, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, ТУЗ-ийн гишүүн Г.Саруул нар ажиллаж байна.



Лувсанвандан БОЛДХУЯГ
 ТУЗ-ийн дарга, Бодь Группын
 үүсгэн байгуулагч

Мэргэжил:
 Эдийн засагч

Боловсрол:
 1974-1984 онд Монгол Улс, Улаанбаатар хот, Бүрэн дунд боловсрол
 1984-1985 онд Монгол Улсын Их Сургуулийн Герман хэлний анги
 1985-1986 онд Унгар, Карл Марксын Их сургууль, түүх судлаач
 1986-1991 онд Герман, Гумбольдтын Их сургууль, түүх судлаач
 1991-1995 онд Герман улсын өмч хувьчлалын газарт судалгаа шинжилгээний ажил, их сургуулийн
 дадлага

Ажилласан туршлага:
 1995 оноос Герман улс дахь Монголиа Хаус Файненшиал Сервисес компанийн захирал,
 1996-2000 оны хооронд Голомт Банкны ТУЗ-ийн дарга, Бодь Интернэшнл группийн Ерөнхийлөгч,
 2000 оноос Бодь Интернэшнл компанийн Ерөнхий захирал, Бодь Даатгал компанийн ерөнхийлөгч, Голомт Банкны
 ТУЗ-ийн гишүүн, СОС Интернэшнл Медика Монголиа эмнэлгийн удирдах зөвлөлийн гишүүн, Доктор, Профессор
 Лувсанвандан сангийн тэргүүн, Монголын Бизнес Эдийн засгийн дээд сургуулийн хүндэт доктор, Монголын
 гандболын холбооны дэд ерөнхийлөгч, Монголын Үйлдвэрлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн,
 2005 оноос Бодь Группын ерөнхийлөгч, Шведийн Вант улс дахь Өргөмжит Ерөнхий Консул,
 2004-2007 оны хооронд Голомт Банкны ТУЗ-ийн дарга,
 2009 онд Бодь Даатгал ХХК-ийн Ерөнхийлөгч, Бодь Группын Ерөнхий захирал, Шведийн Вант улсын Өргөмжит
 Ерөнхий Консул, Монголын Поло Холбооны Ерөнхийлөгч, Хаан Поло Клубыг үүсгэн байгуулагч,
 2011 онд Бодь Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Шведийн Вант улсын Өргөмжит Ерөнхий Консул,
 2014 онд Бодь Группын ерөнхийлөгч, Лувсанвандан сангийн тэргүүн, Лувсанвандан Арт Галерейг үүсгэн
 байгуулагч

Компанийн засаглалын сургалт
 КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2014 оны 9 сарын 6-нд
 гэрчилгээ авсан.

Гэрчилгээний дугаар:
 1030022



Ганбаатар САРУУЛ
 Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн
 гишүүн

Мэргэжил:
 Эдийн засагч

Боловсрол:
 1999-2003 онд АНУ, Лоёола их сургууль, эдийн засагч

Ажилласан туршлага:
 АМП Фьючерс компанийн Ази, Орос, ТУХН-ийн орнуудыг хариуцсан Газрын захирал,
 2010 оноос Сангийн яамны зөвлөх,
 2011 оноос Монголын Хөрөнгийн Биржийн Тэргүүн дэд захирал, валютын захын үүсмэл хэрэгслүүд хариуцсан
 Ахлах трейдер, Розентал Коллинс групп болон Мобиум Ипотекийн группд Ахлах банкир, Бодь Группын
 Гүйцэтгэх захирал, Бодь даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга

Компанийн засаглалын сургалт
 КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2014 оны 9 сарын 6-нд гэрчилгээ
 авсан.

Гэрчилгээний дугаар:
 1030021



Жамбалсүрэн НАРАНТУЯА
 ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил:
 Эдийн засагч, хуульч

Боловсрол:
 1978-1983 онд ОХУ, Кубанийн Улсын Их Сургууль, эрх зүйч

Ажилласан туршлага:
 1983-1989 оны хооронд Улсын дээд шүүхийн зааварлагч,
 1989-1990 оны хооронд Сүхбаатар Дүүргийн шүүхийн шүүгч,
 1991-1992 оны хооронд Улсын бага хурлын зөвлөх,
 1992-1998 оны хооронд УИХ-ын Тамгын газарт зөвлөх, ахлах зөвлөх,
 1998-2008 оны хооронд УИХ-ын Тамгын газарт Нэгдүгээр нарийн бичиг,
 2009-2010 оны хооронд УИХ-ын даргын зөвлөх,
 2010-одоог хүртэл Олон Улсын Санхүүгийн Корпорацид Хуулийн зөвлөх

Компанийн засаглалын сургалт
 КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2020 оны 9 сарын 26-нд гэрчилгээ
 авсан.

Гэрчилгээний дугаар:
 0521088



ЖАН ТОРСТЭН Дазер
 ТУЗ-ийн гишүүн


Мэргэжил:
 Санхүү эдийн засгийн магистр, эдийн засагч

Боловсрол:
 1981-1983 онд Герман, Хамбургын Их сургууль, Эдийн засгийн бакалавр
 1983-1985 онд Швейцар, Ст.Галлены коллеж, Санхүү эдийн засгийн магистр

Ажилласан туршлага:
 Швейцар Улсын Солюшн Партнерс Глобал ХК үүсгэн байгуулагч,
 Таск Мерчант Капитал ХХК гүйцэтгэх захирал,
 Бизнесийн шинжилгээ Стратегийн Свисс партнерс ХК хөрөнгө оруулалтын банкны удирдах зөвлөлийн гишүүн,
 Жэй Пи Морган партнер,
 Швейцар Улсын дигитал үйлчилгээний Глобра компанийн ТУЗийн гишүүн,
 Герсон Лехрман Группын шинжээч,
 Бодмер капитал ХК удирдах зөвлөлийн гишүүн

Компанийн засаглалын сургалт
 КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2021 оны 4 сарын 23-нд гэрчилгээ
 авсан.

Гэрчилгээний дугаар:
 0521119



Эрдэнэ БЯМБАЖАВ
ТУЗ-ийн хараат бус ГИШҮҮН

Мэргэжил:

Эдийн засагч

Боловсрол:

ОХУ-ын Эрхүү хотын Санхүү эдийн засгийн дээд сургуульд
Олон улсын Валютын Сангаас зохиосон Зах зээлийн эдийн засаг, менежмент дамжаа
LEADS ХӨТӨЛБӨР

Ажилласан туршлага:

1963-1967 Улсын банкны ерөнхий хороонд мэргэжилтэн
1967-1996 Сангийн яамны валютын хэлтсийн дарга, Сангийн яамны 1-р орлогч сайд, Сангийн сайд (хоёр удаа)
1984-1988 Үнэ, стандартын улсын хорооны дарга
1989-1992 Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооны 1-р орлогч дарга, Засгийн газрын гадаад эдийн засгийн хорооны 1-р орлогч дарга,
Монгол-Зөвлөлтийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн орлогч
1992-1994 Казакстан улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд
1996 Оноос Санхүүгийн зөвлөгөө өгөх "Их тусч" ХХК-ийн захиралаар
Одоогийн байдлаар "Бодь даатгал" ХХК-ий ТУЗ-ийн хараат бус гишүүн



Рожер Томас Мойес
ТУЗ-ийн хараат бус ГИШҮҮН

Мэргэжил:

Эрх зүйч

Боловсрол:

1980 – Калифорнийн их сургууль, Эрх зүй, түүх, удирдахуйн ухааны чиглэлээр Бакалавр
1988- Массачусетсийн Тафтсын их сургууль, Эрх зүй ба дипломатын чиглэлээр Магистр

Ажилласан туршлага:

2019.04 – одоогоор FSIP төслийн Финтекийн ахлах зөвлөх
2018-2021 – DaNa Facility – санхүүгийн ахлах зөвлөх
2015-2020 – Азийн хөгжлийн банк – Санхүүгийн шинжээч, санхүүгийн ахлах зөвлөх
2012-2015 – Дэлхийн банкны Хөдөө аж ахуйг дэмжих сан – Зөвлөх
2008-2011 – Олон улсын санхүүгийн корпораци – Санхүүгийн мэргэжилтэн
1981-2008 – Азийн хөгжлийн банк, MAS International, Development Alternatives, Swiss Bank Corporation -нд Гүйцэтгэх захирал,
Ахлах зөвлөх, Санхүүгийн мэргэжилтэн



Базарсад ОЙГОНЖАРГАЛ
ТУЗ-ийн гишүүн

Мэргэжил:

Эдийн засагч

Боловсрол:

1999 - 2001 Санхүү эдийн засгийн их сургууль, Банк зээлийн эдийн засагч - Санхүүч
2006 - 2008 Удирдлагын академи, Удирдахуйн ухааны магистр

Ажилласан туршлага:

2004 - 2020 Жем Интернэшнл ХХК, Ерөнхий захирал
2020 - одоог хүртэл Жем Интернэшнл ХХК, Ерөнхийлөгч



ЭЛЛИОТ РОВАН Аукланд
ТУЗ-ийн гишүүн

Мэргэжил:

CIMA, Санхүүгийн удирдлага

Боловсрол:

1996-2004 онд Их Британи Улс, Оксфордын Их сургууль, Эдийн засгийн бакалавр

Ажилласан туршлага:


2006-2015 оны хооронд Ти Эйч Си Партнерс-т шинжээч,
2015-2017 оны хооронд Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкны Зөвлөх, Хөрөнгө оруулагчдын харилцаа,
үнэлгээ, Бүтцийн санхүүгийн албаны дарга,
2017-одоог хүртэл Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкны Бизнесийн төлөвлөлт, санхүүгийн загварчлалын
албаны дарга

Компанийн засаглалын сургалт

КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2021 оны 4 сарын 23-нд гэрчилгээ
авсан.

Гэрчилгээний дугаар:

0521120



Дэмчигжав МОЛОМЖАМЦ
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Мэргэжил:

Эдийн засагч, Доктор профессор

Боловсрол:

1970-1975 онд ОХУ Санхүү эдийн засгийн бакалавр, Улс ардын аж ахуйн дээд сургууль
1985-1987 онд ОХУ Эдийн засгийн дэд доктор, Санхүү эдийн засгийн сургууль
1997-1999 онд ОХУ Эдийн засгийн доктор цол, Санхүү эдийн засгийн сургууль

Ажилласан туршлага:

1975-1990 оны хооронд Сангийн яаманд Монгол Улсын Сангийн сайд, Төсвийн газрын дарга, Валютын газрын
дарга,
1990-1992 оны хооронд Монгол Улсын Засгийн газарт Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга,
1992-1996 оны хооронд Монгол Банкны Ерөнхийлөгч,
1997-2001 оны хооронд Эдийн Засаг Хамтын Ажиллагааны Олон улсын байгууллагад Орлогч дарга,
2012-2016 оны хооронд Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банканд Орлогч дарга

Компанийн засаглалын сургалт

КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8 хэсэгт заасны дагуу сургалтад хамрагдаж 2020 оны 9 сарын 26-нд гэрчилгээ
авсан.

Гэрчилгээний дугаар:

0521091

БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

1. Онцлох үйл явдлууд

- Шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Борлуулалтын суваг, тэлэлт
- Хамтын ажиллагаа
- Арга хэмжээ, нийгмийн хариуцлага

2. Санхүүгийн үзүүлэлтүүд

3. 2023 оны тоон зорилт

ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



Corporate gateway үйлчилгээ

“Corporate gateway” үйлчилгээ нь өөрийн санхүүгийн программаар дамжуулан банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжийг олгоно.



Prime, Prime reserve кредит карт

Дэлхийн хаана ч төлбөр тооцоо хийх боломжийг харилцагчдад олгохоос гадна тусгайлсан Prime багцын үйлчилгээ, зээлийн уян хатан нөхцөл нь таны **санхүүгийн хэрэгцээг бүрэн шийдвэрлэнэ.**



B-Point цуглуулан хадгаламждаа нэмэх боломжтой

B-Point оноогоо цуглуулан эзэлээ төлж, картаа захиалах, сунгах болон бусдад шилжүүлэх гэсэн үйлчилгээнүүдийг авдаг байсан бол одоо нэмэлтээр **хугацаатай хадгаламж руугаа B Point** оноогоо хөрвүүлэх боломжтой.



Хугацаатай хадгаламжаа хоногоор сонгоорой

Та заавал сар жил гэж сонгохгүйгээр өөрт тохирсон хугацаагаар хадгаламжийн хугацааг сонгох боломжтой.

ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



Экспресс автомашины зээл

Хамгийн түргэн шуурхай шийдвэрлэдэг Экспресс автомашины зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн.



Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээл

Бичил, жижиг бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих, тогтвортой явуулахад шаардлагатай эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг санхүүжүүлэх зорилготойгоор энэхүү зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн.



Дансны дугаар сонгох үйлчилгээ

Өөрийн банкны дансыг дуртай хүссэн тоогоороо сонгож нээх үйлчилгээг нэвтрүүлэв.



ХҮҮХДИЙН ХАДГАЛАМЖ

Хүүхдийн хадгаламжийн шинэ дүр төрх

Хүүхдийн хадгаламжийг "Итгэл" нэртэйгээр буюу шинэ дүр төрхөөр зах зээлд нэвтрүүлж, урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

БОРЛУУЛАЛТЫН СУВАГ, ТЭЛЭЛТ

Мэдээллийн сангийг датагуардтай холбож, сүүлийн үеийн хүчин чадалтай сервер лүү шилжүүлэн өгөгдлийн сангийн сайжруулалтын тохиргоо хийснээр онцгой байдлын үед нөөц төв рүү шилжих хугацааг 5 мин дотор гүйцэтгэх боломжтой болгосон. Мөн баазын ачааллыг 200%-иар бууруулав.



ПОС төхөөрөмжөөс E-barimt хэвлэх боломжийг нэвтрүүлсэн.

Шинээр Драгон салбарыг нээж, үйл ажиллагааг эхлүүлсэн



BOGD MOBILE нэвтрүүлэлт, хөгжүүлэлт:

- Favorite / Recent гүйлгээ
- Данс болон картын гүйлгээний лимит
- Картын тохиргоо хаах / нээх
- Карт захиалгын явц
- Шуурхай гүйлгээ
- БОГД булан
- World Cup- Тааварт тоглоом

Шинээр Яармаг салбарыг нээж, үйл ажиллагааг эхлүүлсэн.



Үндсэн систем NES-ийн НӨАТ болон Баталгааны модуль шинээр нэвтрүүлсэн.

ХАМТЫН АЖИЛЛАГАА



ENABLING CAPITAL ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГААС АМЖИЛТТАЙ САНХҮҮЖИЛТ ТАТСАН

2022 оны 7-р сарын 7-ний өдөр анхны зээлийн гэрээн байгуулсан бол 2022 оны 10-р сарын 26-ний өдөр хоёр дахь зээлийн гэрээгээ байгуулан нийт 4 сая ам.долларын дунд хугацааны ЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн санхүүжилтийг Enabling Capital хөрөнгө оруулалтын сангаас амжилттай татан банкны нийт активыг 13.2 тэрбум төгрөгөөр өсгөсөн.



DFC ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГААС 15 САЯ АМ.ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТ ТАТСАН

АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацитай (DFC) 15 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийн гэрээг 2022 оны 12-р сарын 23-ны өдөр амжилттай байгуулан банкны нийт активыг 51 тэрбум төгрөгөөр өсгөх боломжтой боллоо. Энэхүү санхүүжилт нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгч болон ногоон санхүүжилтийг дэмжихэд чиглэснээрээ онцлог юм.



Нийслэлийн ЖДҮ-г дэмжих төвтэй хамтран ажиллав

Нийслэлийн ЖДҮ дэмжих төвтэй хамтран ЖДҮ эрхлэгчдэд цогц санхүүгийн мэдлэг олгох зорилготой 3 талт санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажлыг эхлүүлэв.



БШУ яамтай хамтран ажиллав

БШУЯ-аас хэрэгжүүлж буй "Багш" картын үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааг эхлүүлэв.



ЦХХХЯамтай хамтран лавлагааг цахим болгосон

ЦХХХЯамтай хамтран иргэдээс 69 төрлийн лавлагаа тодорхойлолт шаарддаг байсныг больж буй шинэ үйлчилгээ нэвтрүүлэх санамж бичигт гарын үсэг зурсан.

АРГА ХЭМЖЭЭ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Дэлхийн мөнгөний 7 хоног

Жил бүр зохион байгуулагддаг МБХ-оос зохион байгуулдаг "Дэлхийн мөнгөний 7 хоног" арга хэмжээнд бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулав.



IPO Mongolia 2022 forum

"Ipo Mongolia 2022 Forum" арга хэмжээнд Богд банк ХК нь өөрсдийн бүтээгдэхүүний үйлчилгээ болон банкны хувьцааны талаар сонирхсон иргэдэд мэдээлэл өгч оролцов.



Нархан асрамжийн газарт өдөрлөг зохион байгуулав

Нийгмийн хариуцлагын хүрээнд "Нархан" асрамжийн газрын хүүхэд багачуудад эх үрсийн баярын бэлэг бэлэглэв.



Хүүхэд залуучуудын Z үеийнхэнд Цойлогсод арга хэмжээнд Ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажилласан.



Банкны салбарт анх удаа Дугаараа дугаараа, Мета банкны үйлчилгээ болон Prime reserve credit картын бүтээгдэхүүн нэвтрүүлсэн.



Ирээдүйнхээ төлөө хуримтлуулцаага уриан дор хийгдсэн Дэлхийн хуримтлалын аянд 2-р байр эзэлсэн.

2022

2022
Q1

2022
Q2

2022
Q3

2022
Q4

2023



Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээний салбарт инновац хөгжүүлэх боломж шийдэл форумд Ивээн тэтгэгчээр хамтран ажилласан.



Фантастик продакшны "Зура цурам ажиллагаа" УСК-ны ивээн тэтгэгчээр хамтран ажилласан.



Содон аялгуу реалити шоу нэвтрүүлгийн ивээн тэтгэгчээр хамтран ажилласан.



ТЭРБУМ МОД



Бид яагаад модыг хайрлан хамгаалах ёстой вэ?



ТЭРБУМ МОД


Бид бүхий л үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого журмыг дагаж мөрдөж, тогтвортой санхүүжилттэй холбоотой шинэ санаа, санаачилга гарган ажилладаг бөгөөд "Ногоон" тодорхойлолттой бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Богд банк нь ToC Холбооноос зохион байгуулдаг ToC-ийн хэрэгжилтийн үнэлгээний оноогоо 2022 онд В+ буюу 171.5 оноо авч, 2021 онтой харьцуулахад 23.5 оноогоор нэмэгдсэн байна.

Богд банк нь 2022 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнт аян хөтөлбөрт идэвхтэй оролцохоос гадна өөрсдийн санаачлаагаар Гачууртын Их Дэндий аманд 140 улиас, 40 нарс, 1 гацуур болон 1 шинэс тарьсан. 2022 онд нийт 4 удаагийн мод тарих үйл ажиллагаанд оролцож, зохион байгууллаа.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙТ АКТИВ




Салбарын дундаж активын өсөлт 8.12% байгаа бол Богд банкных **45.08%** байна.

ТУХАЙН ОНЫ АШИГ, АЛДАГДАЛ




Салбарын дундаж цэвэр ашгийн өсөлт 26% байгаа бол Богд банкных **68.47%** байна.


ROE



ROA




АКТИВЫН ХАРЬЦУУЛСАН ИНДЕКС, 2017 ОНЫ СУУРИАР



2017 оныг суурь болгосноор активын өсөлтийг тооцвол Банкны салбарын актив 0.6 дахин өссөн бол Богд банкны актив 5 дахин өсчээ.

ТУХАЙН ОНЫ АШИГ, АЛДАГДЛЫН ХАРЬЦУУЛСАН ИНДЕКС




2017 оныг суурь болгосноор цэвэр ашгийн өсөлтийг тооцвол Банкны салбарын цэвэр ашиг 3 дахин өссөн бол Богд банкны цэвэр ашиг 12.5 дахин өсчээ.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ЗЭЭЛ/Цэвэр/

/сая.төг/




ХАРИЛЦАХ ХАДГАЛАМЖ

/сая.төг/




ЗЭЭЛИЙН ХАРЬЦУУЛСАН ИНДЕКС 2017 оны сууриар




Салбарын дундаж активын өсөлт 10.40% байгаа бол Богд банкны зээлийн дундаж өсөлт 95.30% байгаа нь салбарын дунджаас 9.5 дахин илүү өсөлттэй байна.

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ХАРЬЦУУЛСАН ИНДЕКС, 2017 оны сууриар




Салбарын дундаж харилцах, хадгаламжийн өсөлт 17.47% байгаа бол Богд банкны мөн үзүүлэлт 48.66% байгаа нь салбарын дунджаас илүү өсөлт үзүүлснийг илтгэж байна. Мөн депозитын өсөлтийн хувь жил бүр нэмэгдэж буй нь банкны үйл ажиллагаа өргөжин тэлж, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж байгааг илэрхийлнэ.


ИНТЕРНЭТ, МОБАЙЛ БАНКНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО




НИЙТ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО



ГАДААД ГҮЙЛГЭЭНИЙ ТОО




САЛБАР НЭГЖИЙН ТОО




2023 ОНЫ ТООН ТӨЛӨВЛӨГӨӨ

НИЙТ АКТИВ /сая.төг/




Нийт активыг 196 тэр.төг буюу 42%-иар өсгөж, 675 тэр.төг-т хүргэхээр төлөвлөсөн.

ХҮҮГИЙН ОРЛОГО /сая.төг/




Хүүний орлогыг 31 тэр.төг буюу 71%-иар өсгөж, 79 тэр.төг-т хүргэхээр төсөвлөсөн.

ХҮҮГИЙН БУС ОРЛОГО /сая.төг/




Хүүний бус орлогыг 4,9 тэр.төг буюу 92%-иар өсгөж, 10.3 тэр.төг-т хүргэхээр төсөвлөсөн.

ЦЭВЭР АШИГ /сая.төг/




Цэвэр ашгийг 10 тэр.төг буюу 52%-иар өсгөж, 29 тэр.төг-т хүргэхээр төлөвлөсөн.

ROE




Өөрийн хөрөнгийн өгөөжийг 6 функт буюу 35%-иар өсгөж, 22%-д хүргэхээр төсөвлөсөн.

НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ /сая.төг/




Нийт өөрийн хөрөнгийг 29 тэр.төг буюу 25%-иар өсгөж, 145 тэр.төг-т хүргэхээр төсөвлөсөн.


НИЙТ ЭХ ҮҮСВЭР /сая.төг/




ЗЭЭЛИЙН БАГЦ /сая.төг/



САЛБАРЫН ТОО



ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх

- Бусад ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.
- Одоо байгаа идэвхтэй зээлийн багц дээр ажиллаж, эргэн төлөлтийн хэмжээгээр буцаан зээл олгох ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Харилцагчийн банктай үүсгэсэн харилцаа болон скорингийн мэдээллийг үндэслэн шуурхай шийдвэр гаргаж ажиллана.
- Бизнесийг мөнгөн урсгалалаар нь буюу нийлүүлэлтийн сүлжээгээр санхүүжүүлэх тусгайлан бүтээгдэхүүн нэвтрүүлнэ.

Сургалт, хяналтыг тогтмолжуулах


- Сургалтыг тогтмолжуулж, улирал бүр хяналт хийнэ.
- Мэргэшүүлэх, ур чадвар дээшлүүлэх сургалт гадны болон дотоод мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

Зээл шийдэх процесс сайжруулалт хийх

- Зээлийн скорингийн модуль нэвтрүүлэлтийг эрчимжүүлнэ.
- Зээлийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулж, шийдвэр гаргах хурдыг нэмэгдүүлнэ.
- Шийдвэр гаргах хурдыг нэмэгдүүлэх тал дээр төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. /Тухайлсан бүтээгдэхүүн болон аян зарлана.

Онлайн дижитал суваг

- Онлайн зээлийн төрлийг нэмэгдүүлнэ.
- Buy now Pay Later үйлчилгээг нэвтрүүлнэ.



2023 ОНЫ БАРИМТЛАН АЖИЛЛАХ ЭРСДЭЛИЙН АППЕТИТ

Өөрийн хөрөнгийн өгөөж	ТДЦА/Өөрийн хөрөнгийн дундаж	>10%	$X \geq 20\%$	$20\% > X \geq 0$	$0\% > X$
Активын өгөөж	ТДЦА/Активын дундаж	>2.5%	$X \geq 2.0\%$	$2.0\% > X \geq 0\%$	$0\% > X$
Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ	Нийт өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн актив	>20.0%	$X \geq 25\%$	$25\% > X \geq 12\%$	$12\% > X$
I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	I зэрэглэлийн өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн актив	>20.0%	$X \geq 25\%$	$25\% > X \geq 12\%$	$12\% > X$
Нэг гадаад валютын нээлттэй позиц	Тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц /Өөрийн хөрөнгө	<15%	$ X < 5\%$	$5\% \leq X < 15\%$	$15\% \leq X $
Нийт гадаад валютын нээлттэй позиц	Нийт гадаад валютын нээлттэй позиц /Өөрийн хөрөнгө	<30%	$X \leq 20\%$	$20\% > X \geq 9\%$	$9\% > X$
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	Түргэн борлогдох актив/ТТХ	>32.5%	$X \geq 40\%$	$40\% > X \geq 25\%$	$25\% > X$
Анхаарал хандуулах ангилалтай зээлийн харьцаа	Нийт анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл/Нийт зээлийн үлдэгдэл	<9.8%	$X < 5.0\%$	$5.0\% \leq X < 9.8\%$	$9.8\% \leq X$
Чанаргүй зээлийн харьцаа	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл/Нийт зээлийн үлдэгдэл	<4.5%	$X < 1.8\%$	$1.8\% \leq X < 5\%$	$5\% \leq X$

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

№	Орлогын тайлангийн үзүүлэлт	1/31/2023	2/28/2023	3/31/2023	4/30/2023	5/31/2023	6/30/2023	7/31/2023	8/31/2023	9/30/2023	10/31/2023	11/30/2023	12/31/2023
1	Нийт хүүний орлого	5,182	10,182	15,877	21,494	27,340	33,482	39,979	46,812	53,554	60,638	67,796	75,425
2	Нийт хүүний бус орлого	849	1,634	2,469	3,339	4,185	5,029	5,863	6,715	7,641	8,503	9,346	10,334
3	Нийт орлого	6,031	11,816	18,346	24,834	31,526	38,512	45,843	53,527	61,194	69,141	77,143	85,759
4	Нийт хүүний зардал	(1,901)	(3,775)	(5,947)	(8,096)	(10,286)	(12,691)	(15,247)	(17,992)	(20,707)	(23,511)	(26,408)	(29,504)
5	Зээлийн эрсдэлийн сангийн зардал	(257)	(521)	(861)	(1,117)	(1,503)	(1,696)	(2,127)	(2,343)	(2,706)	(3,185)	(3,766)	(4,196)
6	Нийт хүүний бус зардал	(199)	(512)	(879)	(1,219)	(1,615)	(2,144)	(2,699)	(3,326)	(3,895)	(4,580)	(5,287)	(6,033)
7	Нийт үйл ажиллагааны зардал	(1,031)	(1,987)	(3,107)	(4,141)	(5,138)	(6,150)	(7,324)	(8,361)	(9,411)	(10,625)	(11,702)	(12,780)
8	Орлогын татварын өмнөх ашиг	2,643	5,021	7,552	10,261	12,983	15,831	18,446	21,505	24,475	27,239	29,978	33,246
9	Орлогын албан татвар	(264)	(502)	(805)	(1,162)	(1,522)	(1,898)	(2,243)	(2,647)	(3,039)	(3,404)	(3,765)	(4,197)
10	Цэвэр ашиг	2,379	4,519	6,747	9,098	11,461	13,933	16,203	18,858	21,436	23,836	26,213	29,050

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Хөрөнгө	1/31/2023	2/28/2023	3/31/2023	4/30/2023	5/31/2023	6/30/2023	7/31/2023	8/31/2023	9/30/2023	10/31/2023	11/30/2023	12/31/2023
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	73,859	74,738	76,170	77,247	78,371	79,545	80,771	82,052	83,390	84,789	86,251	87,778
Санхүүгийн хөрөнгө оруулалт	134,311	156,678	159,337	154,965	139,214	173,410	170,435	186,208	178,657	159,641	173,571	168,014
Харилцагчид олгосон зээл/цэвэр дүнгээр/	215,613	226,945	238,201	253,407	270,416	283,752	298,783	314,029	334,926	357,639	376,385	397,215
Эрсдэлийн сан	(3,542)	(3,806)	(4,145)	(4,400)	(4,785)	(4,977)	(5,407)	(5,622)	(5,983)	(6,462)	(7,042)	(7,471)
Бусад хөрөнгө	6,063	6,123	6,185	6,247	6,309	6,372	6,436	6,500	6,565	6,631	6,697	6,764
Үндсэн хөрөнгө	13,587	13,723	13,860	13,999	14,139	14,280	14,423	14,567	14,713	14,860	15,009	15,159
Нийт хөрөнгө	443,433	478,208	493,754	505,864	508,449	557,359	570,848	603,356	618,252	623,560	657,913	674,930
Өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Харилцагчаас татсан эх үүсвэр	192,990	199,401	210,651	218,777	227,310	236,269	245,677	255,555	265,927	276,817	288,252	300,258
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	120,629	146,854	148,925	150,559	142,250	179,732	181,545	201,523	203,471	195,491	216,034	218,210
Бусад өр төлбөр	10,747	10,747	10,747	10,747	10,747	10,747	10,747	10,747	10,747	10,747	10,747	10,747
Нийт өр төлбөр	324,365	357,002	370,322	380,083	380,307	426,748	437,969	467,824	480,144	483,054	515,032	529,215
Өөрийн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хувьцаат капитал	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000
Нэмж төлөгдсөн капитал	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)	(1,443)
Бусад нөөц	(2,104)	(2,106)	(2,108)	(2,110)	(2,112)	(2,114)	(2,116)	(2,118)	(2,121)	(2,123)	(2,125)	(2,127)
Хуримтлагдсан ашиг	22,615	24,755	26,983	29,334	31,697	34,169	36,439	39,094	41,672	44,071	46,449	49,286
Нийт өөрийн хөрөнгө	119,068	121,206	123,432	125,781	128,142	130,611	132,879	135,532	138,108	140,505	142,881	145,715
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	443,433	478,208	493,754	505,864	508,449	557,359	570,848	603,356	618,252	623,560	657,913	674,930

АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

БОГД БАНК ХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгж)

Санхүүгийн Хураангуй Тайлан
2022 оны 12 дугаар сарын 31





Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Богд Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг Богд Банк ХК (“Банк”)–ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу Банкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)–ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2023 оны 3 дугаар сарын 15-ний өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд Аудитын онцгойлсон асуудал багтсан. Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох “Харилцагчдад олгосон зээл ба урьчилгааны үнэ цэнийн бууралт” байсан.

Санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын олон улсын стандарт (“АОУС”) 810 буюу “Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажла”–ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

Ernst & Young Mongolia Audit LLC

Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид



Гарын үсэг зурсан
Мандахбаяр Доржбат
Партнер

Баталсан

Adrian Chu
Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 15

АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

Богд Банк ХК
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
 Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Хураангуй Тайлан

	2022 Мян.төг	2021 Мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	45,611,503	26,708,425
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(16,258,468)	(11,170,933)
Хүүний цэвэр орлого	29,353,035	15,537,492
Шимтгэл, хураамжийн орлого	2,121,638	1,337,388
Шимтгэл, хураамжийн зардал	(602,073)	(493,389)
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	1,519,565	843,999
Арилжааны цэвэр орлого	2,044,326	4,289,583
Үйл ажиллагааны бусад орлого	1,220,937	2,281,200
Нийт үйл ажиллагааны орлого	34,137,863	22,952,274
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	(517,855)	(498,168)
Үйл ажиллагааны цэвэр орлого	33,620,008	22,454,106
Үйл ажиллагааны зардал	(12,393,928)	(9,970,149)
Татварын өмнөх ашиг	21,226,080	12,483,957
Орлогын албан татварын зардал	(2,169,603)	(1,702,975)
Тайлант жилийн ашиг	19,056,477	10,780,982
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал) (татварын дараах):		
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлээний өөрчлөлт</i>	(5,030,295)	(461,933)
<i>Ашиг алдагдлын тайлан руу дахин ангилагдах өрийн хэрэглүүрийн олз/гарз</i>	2,502,234	(129,760)
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлээний өөрчлөлт</i>	(500,000)	-
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)	(3,028,061)	(591,693)
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого	16,028,416	10,189,289

Нэгж хувьцааны ашиг (Төгрөг):

Нэгж хувьцаанд ноогдох суурь болон хөрогдуулсан ашиг 15.2 10.6

2023 оны 3 дугаар сарын 15-ний өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрч, гарын үсэг зурав.

Ганбаатарын Саруул

Гүйцэтгэх захирал

УЛААНБААТАР ХОТ
 69004056 • 9021111168

Моломжамцын Бат-Өлзий

Санхүү хариуцсан захирал

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг оорчлолгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

Богд Банк ХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
Санхүүгийн Байдлын Хураангуй Тайлан

	2022 оны 12 сарын 31 Мян.төг	2021 оны 12 сарын 31 Мян.төг
ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	127,975,910	106,311,464
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	51,241,913	26,421,661
Санхүүгийн хөрөнгө оруулалт	69,625,463	36,669,786
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	433,677	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	208,605,193	147,910,917
Бусад хөрөнгө	11,143,051	4,919,677
Борлуулах зорилготой хөрөнгө	1,468,263	1,034,300
Үндсэн хөрөнгө	4,197,543	2,893,119
Ашиглах эрхтэй хөрөнгө	2,760,642	2,845,683
Биет бус хөрөнгө	931,856	855,851
НИЙТ ХӨРӨНГӨ	478,383,511	329,862,458
ӨР ТӨЛБӨР		
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	43,347,904	24,793,633
Буцаан худалдан авах хэлцэл	65,471,192	49,712,396
Харилцагчдын харилцах, хадгаламж	217,242,434	137,114,273
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	62,118	-
Зээлийн санхүүжилт	27,137,624	8,212,568
Бусад өр төлбөр	4,333,099	4,328,126
Түрээсийн өр төлбөр	2,955,777	2,994,860
Орлогын татварын өглөг	1,213,285	909,940
НИЙТ ӨР ТӨЛБӨР	361,763,433	228,065,796
ЭЗДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	98,556,822	80,306,822
Бусад нөөц сан	(1,579,154)	928,997
Хуримтлагдсан ашиг	19,642,410	20,560,843
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	116,620,078	101,796,662
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	478,383,511	329,862,458

2023 оны 3 дугаар сарын 15-ний өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрч, гарын үсэг зурав.



Ганбаатарын Сарууд
Гүйцэтгэх захирал

Молонжамцын Бат-Өлзий
Молонжамцын Бат-Өлзий
Санхүү харуцсан захирал

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2023.03.15

№ 23/26

Улаанбаатар хот

Аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайланг хүлээн авч баталгаажуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.5, 31.3.9, “Богд банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Эрнст энд Янг Монголия аудит ХХК /Ernst & Young Mongolia Audit LLC/-ийн аудитласан 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч банкны 2022 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Банкны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтэд Богд банкныг төлөөлөн гарын үсэг зурж баталгаажуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Саруул/, Санхүүгийн удирдлагын газар /М.Бат-Өлзий/-нарт зөвшөөрсүгэй.

3. Банкны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулахыг Гүйцэтгэх захирал Г.Саруул-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2023.02.08

№ 23/09.

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлийн 47.3, 76 дугаар зүйлийн 76.1.12 дэх заалт, 80 дугаар зүйлийн холбогдох заалтууд, Банкны тухай хуулийн 29, 35 дугаар зүйл, Богд банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22/125 тоот тогтоолын арван дөрөвдүгээр хавсралтаар баталсан Богд Банк ХК-ийн Ногдол ашгийн журам, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хурлыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Богд Банк” ХК нь 2022 оны 2-р хагас жилийн санхүүгийн урьдчилсан байдлаарх татварын дараах цэвэр ашиг болох 11,096,397,566.86 төгрөгийн 25% болох 2,774,099,391.72 төгрөгийн ногдол ашгийг нийт эргэлтэд байгаа 1,250,000,000 ширхэг хувьцаанд тооцон мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг 2.2193 төгрөг байхаар тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон Үнэт цаасны компаниудаар дамжуулан эрх бүхий этгээдийн зөвшөөрөл шийдвэр ирснээс хойш 60 хоногийн дотор ногдол ашгийг хуваарилсугай.
5. Энэхүү тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх Захирал /Г.Саруул/ -д үүрэг болгосугай.
6. Тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
7. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
8. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ



2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

МЯНГАН.ТӨГРӨГӨӨР

Д/Д	Зардлын ангилал	2022 оны 5 сараас -2023 оны 4 сар /жилийн дүн/
НИЙТ ТӨСӨВ /ЗАРДАЛ + ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ/		291,127.5
1	Нийт зардлын төсөв. Үүнээс:	291,127.5
	1 Цалин хөлс түүнтэй холбоотой зардал	291,127.5
	2 Ашиглалтын зардал	
	3 Бичиг хэрэг, хангамжийн материалын зардал	
	4 Харилцаа холбооны зардал	
	5 Автомашин түүнтэй холбоотой зардал	
	6 Томилолт, зочны зардал	
	7 Үйл ажиллагааны бусад зардал	
	8 Зочин төлөөлөгч баяр ёслолын зардал	
2	Хөрөнгө оруулалтын төсвийн нийт дүн	
	1 Техник, тоног төхөөрөмж	

“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Саналын хуудасны Хавсралт-1/ТӨСӨЛ

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7 дэх заалт, “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон “Богд Банк” ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Богд Банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс өгсөн “хангалттай сайн” гэх дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Энэхүү ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Саналын хуудасны Хавсралт-2/ТӨСӨЛ

Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6 дэх заалт, “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.8 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлантай танилцаж, хэлэлцсэний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Богд Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж ТУЗ-н 2023 оны зардлын төсвийг Хавсралт-1-н дагуу баталсугай.
2. Энэхүү ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Саналын хуудасны Хавсралт-3/ТӨСӨЛ

Компанийн ТУЗ-ийн гишүүнийг шинээр сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Аукланд Эллиот нь чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгосугай.
2. Чөлөөлөгдсөн “Богд Банк ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний оронд “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Рэнцэндорж овогтой Баясгаланг 3 жилийн хугацаатайгаар сонгож томилсугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ



**Рэнцэндорж
БАЯСГАЛАН**

Мэргэжил:

Санхүү эдийн засагч

Боловсрол:

1986-1996 онд Монгол улс, Улаанбаатар хот, Лаборатори 1-р сургууль

1997-2001 онд Монгол улс, Улаанбаатар хот, МУИС- Эдийн засгийн сургууль, Бизнесийн удирдлагын Бакалавр

2010-2014 онд Их Британи, Оксфорд хот, Оксфордын Их Сургууль, Бизнесийн удирдлагын Магистр

Ажилласан туршлага:

2001-2002 оны хооронд, Хаан банк, Зээлийн мэргэжилтэн

2002-2009 оны хооронд, Монгол банк, Ахлах эдийн засагч

2009-2011 оны хооронд, Азийн хөгжлийн банк, Эдийн засагч

2013-2014 оны хооронд Олон улсын валютын сан, Ахлах судалгааны мэргэжилтэн

2014-2018 оны хооронд, Олон Улсын Баялагийн Сангийн Форум, Ахлах менежер

2019-2021 оны хооронд, Milken Institute, Associate Deirector

2021-2022 оны хооронд, Council for Inclusive Capitalism, Head of Partnership

2022 оноос эхлэн АНУ-ын Вашингтон хот дахь хөрөнгө оруулалтын зөвлөгөө, судалгааны төрөлжсөн Дэлфос Интернэшнл (Delphos International) байгууллагад хөрөнгө оруулалт, зах зээл хөгжүүлэлтийн зөвлөхөөр ажиллаж байна.

БОГД БАНК" ХК-ИЙН ТУЗ-Н ГИШҮҮНИЙГ СОНГОХ САНАЛ АВАХ ХУУДАС

"Богд Банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 13-ны өдрийн 23/22 тогтоолын тавдугаар хавсралт

1.	Хувьцаа эзэмшигчийн нэр:	
2.	Регистрийн дугаар:	
3.	Эзэмшиж байгаа хувьцааны төрөл:	Энгийн
4.	Эзэмшиж буй хувьцааны тоо:	ширхэг
5.	Бүртгэсэн /Үнэт цаасны компани/	
6.	Брокерын овог нэр:	

"Богд Банк" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11 цагт болно.

Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал хураана.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ТУЗ-ийн гишүүн сонгох			
	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч	Рэнцэндорж овогтой Баясгалан	
Санал өгсөн хувьцаа эзэмшигч:			
Саналын хуудас хүлээн авсан брокер: /Гарын үсэг, тэмдэг/			
2023 оны ____ сарын ____ өдөр			
Саналын хуудсыг хүчинтэйд тооцсон тооллогын комиссын дарга:			
Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:			

Саналын хуудсыг бөглөх санамж:

Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана.
- Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч нь А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

- **Хувилбар А:** Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
- **Хувилбар Б:** Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

“Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 23/22 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралт

1.	Хувьцаа эзэмшигчийн нэр:	
2.	Регистрийн дугаар:	
3.	Эзэмшиж байгаа хувьцааны төрөл:	Энгийн
4.	Эзэмшиж буй хувьцааны тоо:	ширхэг
5.	Үнэт цаасны компани дахь бүртгэлийн дугаар:	
6.	Бүртгэсэн ҮЦК-ийн нэр:	
7.	Брокерын овог нэр:	

№	Хэлэлцэж, батлах асуудлууд	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн	Татгалзсан	Татгалзсан бол таны өгөх санал
1	“Богд банк” ХК-ийн 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;	Шийдвэрийн төсөл №1				
2	Ногдол ашиг хэрхэн хуваарилах гэж байгаа талаар товч танилцуулга;	Шийдвэр гарахгүй. Танилцуулах	—	—	—	—
3	ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах;	Хурлын материалд байгаа ХЭ-ийн ээлжит хурлаас гарах хоёр дугаар шийдвэрийн төсөл				

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг
Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр Гарын үсэг: _____	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр Улсын бүргэлийн дугаар: _____
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр: _____ Регистрийн дугаар: _____	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр: Албан тушаал: _____ Гарын үсэг: _____
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:	

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд (доогуур зурах) тооцон тоолсон

Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр

Тооллогын комиссын Дарга: _____
 Гишүүн: _____
 Гишүүн: _____
 Гишүүн: _____
 Гишүүн: _____

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

Хувьцаа эзэмшигч та танд илгээсэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай мэдэгдэлд заасан хурлаас гарах шийдвэрийн төсөл болон түүнтэй холбоотой бусад материалтай 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн дотор танилцан энэхүү саналын хуудсыг доор заасны дагуу бөглөн ирүүлнэ үү.

Саналын хуудсыг бөглөх санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) эсхүл (✓) гэсэн тэмдэглэгээг хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+) эсхүл (✓), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (+) эсхүл (✓), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (+) эсхүл (✓) тэмдэг тавина.
2. Хэрэв татгалзсан бол та тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа татгалзсан бол таны өгөх санал гэсэн багананд бичнэ үү
3. Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн бол санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хэрэв та Саналын хуудаст энэхүү санамжийн 1-т заасан тэмдэглэгээний аль нэгийг хийгээгүй бол Түдгэлзсэнд тооцно.
5. Хэрэв та Саналын хуудсыг буруу бөглөсөн бол Санал өгөгч нь Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө Саналын хуудсыг дахин авч бөглөж болно.
6. Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол энэхүү санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, үйлчлүүлдэг үнэт цаасны компаниараа дамжуулан манайд илгээнэ үү.

Хурал : 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11:00 цагт цахимаар болно



БОГД БАНК

ХУВЬЦААТ КОМПАНИ



Богд цамхаг - 4-н давхар, Жигжиджавын гудамж,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар 15160, МОНГОЛ УЛС

Утас: +976 7577 1199
Факс: +976 11 328311
Вэб: www.bogdbank.com
И-мэйл: info@bogdbank.com